

**“ТАВАНТОЛГОЙН НҮҮРС АЧИХ  
ЛОГИСТИКИЙН ТӨВ” ТӨСЛИЙН 2022 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

**ЗАХИАЛАГЧ: “ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК**

**ГҮЙЦЭТГЭГЧ: “БОДЬ ИНТЕРНЭШНЛ” ХХК**

## **АГУУЛГА**


БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	3
БҮЛЭГ 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	4
БҮЛЭГ 3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ..	11
БҮЛЭГ 4. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	11
БҮЛЭГ 5. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	11
БҮЛЭГ 6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ .....	11
БҮЛЭГ 7. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ_УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .	12
БҮЛЭГ 8. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН_СУУГЧИД, ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ .....	13
ХАВСРАЛТ МАТЕРИАЛ.....	12

## БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төв” нь экспортыг нэмэгдүүлэх, өртгийг бууруулах зорилгын хүрээнд Монгол Улсын засгийн газрын шийдвэрээр хэрэгжүүлж буй томоохон төсөл хөтөлбөр билээ. Энэхүү төсөл нь “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Үйлдвэрлэл, санхүү, эдийн засгийн төлөвлөлтийг богино, дунд хугацаанд тодорхойлж, компанийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор боловсруулсан 2021-2025 оны дунд хугацааны А6/20 Бизнес төлөвлөгөө, мөн компанийн Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-өөс баталсан 2020 оны хөрөнгө оруулалтын төсөв, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл юм.

Энэхүү нүүрс ачих логиستيкийн төвийг барьж байгуулснаар “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн экспортыг нэмэгдүүлэх, тээврийн зардлыг бууруулах чухал ач холбогдолтой юм.

Энэхүү байгууламж нь ил уурхай, нүүрс баяжуулах үйлдвэр, төмөр замын төлөвлөгөөтэй уялдан хүчин чадлыг тооцож төслийг хэрэгжүүлэх 2 үе шаттай байхаар төлөвлөсөн бөгөөд 1-р үе шат 2022 оноос жилийн 20 сая.тн хүчин чадалтай, 2-р үе шат 2024 оноос хүчин чадлыг 35 сая.тн хүртэл өргөжүүлэх боломжтой.



Зураг 1 . Төслийн хамрах хүрээ

ТНАЛТ-ийн төслийг үндсэн 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Төсөл хэрэгжүүлэх үе шат нь Баруун цанхи, Зүүн цанхи, Бортээгийн ил уурхайн үйл ажиллагаа, вагон тээврийн төлөвлөлттэй уялдан хэрэгжинэ.

**БҮЛЭГ 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

*Хүснэгт 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Зардал, төг
<b>1. АГААР ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР</b>				
Барилгын ажлын талбайгаас болон шороон замаас тоос дэгдэж хүрээлэн буй орчинд тархах	Зам, талбайг услах. Барилгын ажлын үед үүсэх тоосжилтыг дарахын тулд	Төслийн талбай	Төслийн талбайн түр замуудын усалгаанд 770 м <sup>3</sup> ус ашиглаж түр замуудаас үүсэх орчны тоосжилтыг бууруулж ажилласан.  Мөн тээврийн хэрэгслийн түр зам дээр зорчих хурдны дээд хязгаарыг “Төслийн замын хөдөлгөөний удирдлагын журам” -д том оврын машин 40 км/цаг, суудлын машин 60 км/цаг байхаар зааж өгсөн ба зорчих хэсгийн хурдны хязгаарт тогтмол хяналтыг тавьсан.	154,000.0
<b>2. ХӨРС БА УРГАМЛАН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР</b>				
Төслийн нөлөөгөөр орчны үржил шимт хөрс, ургамлан бүрхэвч бүхий талбай барилга байгууламж, хүнд даацын машин техникийн үйл ажиллагааны нөлөөнд өртөж, хөрсний элэгдэл, эвдрэл үүсэж ургамлан бүрхэвч сөрөг нөлөөлөлд өртөнө.	Төсөл хэрэгжүүлэх талбай, барилгын ажилд ашиглагдах шороон замуудын маршрутыг тогтоож тэмдэгжүүлэх	Төслийн талбайд ажилд ашиглагдах шороон замууд	Түр кемп, төсөл хэрэгжүүлж буй талбайд технологийн түр замуудыг тавьж хөрсний элэгдэл эвдрэлээс урьдчилан сэргийлж, салаа зам гарсан тохиолдолд яаралтай хаалгах, ажилчдад сургалт зохион байгуулж орох зэрэг хариу арга хэмжээ авч ажилласан.	Дотоод үйл ажиллагааны зардал

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Зардал, төг
<b>3. ГАЗРЫН ДООРХ УСАНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР</b>				
Усыг тооцоогүй ашигласнаас газрын доорх усны нөөц хомсдох	Барилгын ажилд ус авч ашиглах гүний худгийг тоолууржуулах	Худаг	<p>Ерөнхий гүйцэтгэгч “Бодь интернэшнл” ХХК-ийн барилга угсралтын туслан гүйцэтгэгч “Говь инфрастраткер партнерс” ХХК нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-тай 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдөр № ЭТТ-СА-2022/09 дугаартай “Ус ашиглах, ашиглуулах гэрээ”-г байгуулж 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хамтран ажилласан.</p> <p>Тус гэрээний дагуу №18, №05 гэсэн нийт 2 худаг ашигласан ба “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн эзэмшлийн худаг тус бүрт баталгаажуулж лацадан тоолуур суурилуулсан байна.</p>	Дотоод үйл ажиллагааны зардал
<b>Нийт зардал, төг</b>				<b>154,000</b>

## 2.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдсэн ажлууд:

Бид “Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв” төслийн барилгын ажлын явцад хүрээлэн буй орчны агаарын чанарт дараах сөрөг нөлөөллүүд үүсч болзошгүй хэмээн үзэж сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажилласан.

### 2.1.1. Орчны тоосжилтыг бууруулах чиглэлээр хийгдсэн ажлууд:

Бид орчны тоосжилтыг бууруулах зорилгоор төслийн талбайн түр замуудын усалгаанд 770 м<sup>3</sup> ус ашиглаж түр замуудаас үүсэх орчны тоосжилтыг бууруулж ажилласан. Мөн тээврийн хэрэгслийн түр зам дээр зорчих хурдны дээд хязгаарыг “Төслийн замын хөдөлгөөний удирдлагын журам” -д том оврын машин 40 км/цаг, суудлын машин 60 км/цаг байхаар зааж өгсөн ба зорчих хэсгийн хурдны хязгаарт тогтмол хяналтыг тавьсан.



Зураг 2.1, 2.2 Түр замын усалгаа, түр замын засвар арчилгаа хийж буй байдал

### 2.1.2 Хөрс ба ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдсэн ажлууд:

Хөрс болон ургамлын бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Төсөл хэрэгжүүлэх талбай, барилгын ажилд ашиглагдах шороон замуудын маршрутыг тогтоож тэмдэгжүүлсэн.
- Төслийн үйл ажиллагааны явцад салаа зам үүсгэхгүй байхад онцгойлон анхаарч хяналт тавьсан.





48T 541815 4832405  
Nov 16, 2022 12:59:15



48T 542582 4832226  
Nov 16, 2022 12:56:54



48T 542588 4832222  
Nov 16, 2022 12:56:43



**Зураг 2.3-2.9 Ажилчдын түр кемп, төсөл хэрэгжүүлэх талбай, барилгын ажилд ашиглагдах шороон замуудын маршрутыг тогтоож тэмдэгжүүлсэн.**

### 2.1.3. Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг буруулах чиглэлээр хийгдсэн ажлууд

Ерөнхий гүйцэтгэгч “Бодь интернэшнл” ХХК-ийн барилга угсралтын туслан гүйцэтгэгч “Говь инфрастраткер партнерс” ХХК нь “Эрдэнэс тавантолгой” ХК-тай 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдөр № ЭТТ-СА-2022/09 дугаартай “Ус ашиглах, ашиглуулах гэрээ”-г байгуулж 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хамтран ажилласан.

Тус гэрээний дагуу Эрдэнэс тавантолгой ХК эзэмшлийн №18, №05 гэсэн нийт 2 /худаг тус бүрт баталгаажуулж лацадсан тоолууртай/ худагас ус авч ашигласан.



*Зураг 2.10-2.13 Ус ашиглах, ашиглуулах гэрээний дагуу инженерийн хийцлэл бүхий байр, тоноглол, баталгаат тоолуур суурилуулсан №18, №05 гүний худгийн байгууламж*



### БҮЛЭГ 3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 2. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Зардал, төг
Ажиллагсдын түр кемпийн орчим 0.01 га- д мод тарих	Бэлтгэл ажил	Техник тоног төхөөрөмж, судалгаа шинжилгээ, төсөл боловсруулалт	Цогтцэций сумын нутагт хамаарах ажилчдын түр кемп дотор 0.01 га талбайд 300ш гаруй Хайлаас мод тарьж, арчлан ургуулж байна.	750,000.0
<b>Нийт зардал, төг</b>				<b>750,000</b>

## Орчны тохижилт



*Зураг 3.1, 3.2 Ажилчдын түр кемп дотор зурвас байдлаар хайлаас мод тарьсан байдал*

## БҮЛЭГ 4. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


*Хүснэгт 3. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт*

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Зардал, төг
<b>1.БАЙГАЛИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР</b>				
Цаг агаарын гэнэтийн үзэгдлээс үйл ажиллагаа доголдох, зогсох	Цаг агаарын улирлын, сарын, 7 хоногийн, өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд тогтмол ашиглах	Төслийн талбай	Төслийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах зорилгоор “Бодь Интернэшнл” ХХК бусад бүх хэлтсүүд рүү цаг агаарын 7 хоногийн өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг 7 хоногт нэг удаа тогтмол явуулж болзошгүй цаг агаарын аюултай нөхцөл байдлаас урьдчилан сэргийлдэг.	480,000
Гал түймрийн улмаас төслийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд Танилцуулах	Төслийн талбай	ХАБЭА-н тухай хууль болон MNS4969:2000 ХАБЭА-н сургалт зохион байгуулах, үндсэн дүрэмийн дагуу 2022 онд ХАБЭА-н шинэ ажилтаны сургалтаар 157 хүнд 471 хүн/цаг галын аюулгүй байдлын тухай сургалтаар 54 хүнд 162 хүн/цаг сургалт орсон.	Дотоод үйл ажиллагааны зардал
	Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу	Төслийн талбай	Галын аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, гал түймэртэй тэмцэх анхан шатны багаж хэрэгсэл, галын хор, галын булангуудыг стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг хангасан. “Бодь интернэшнл” ХХК-ийн үндсэн кемпүүдийн амрах өрөө бүрд болон 25м <sup>2</sup> тутамд 1 ширхэг 4кг-тай галын хор байхаар тооцоолж	1,440,000

	байрлуулж бэлэн байдлыг хангаж ажиллах		байрлуулсан ба шинээр бөмбөлөгөн галын хорыг байрлуулсан. Сар бүр бүрэн бүтэн байдлыг шалгаж үзлэг хийгддэг.	
<b>2.ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР</b>				
Үйлдвэрлэлийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлөх	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих	Төслийн талбай	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй байгаль орчны дүрэм журмын хэрэгжилтэнд ХАБЭА-н тухай хуулийн 5 бүлэг Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зохион байгуулалт дагуу төслийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй бүхий л аж ахуйн нэгжүүд зохион байгуулалт хийдэг. Захиалагч болон ерөнхий гүйцэтгэгч хэрэгжилтэд давхар хяналт тавьж, заавар зөвлөмж өгч сайжруулалтыг тогтмол хийн ажилладаг. Төслийн хүрээнд дотоод хяналтын журмыг хэрэгжүүлж, хэвшүүлэх ажлыг эхлүүлээд байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Ээлжийн туршид хийнэ / ХАБЭА хариуцсан ажилтан ИТА-тай хамтарч удирдан зохион байгуулж хийх/</li> <li>• Аюулгүй ажиллагааны хэлтсийн дээд түвшний удирдлагаар удирдуулсан комисс (комиссын бүрэлдэхүүнийг аюулгүй ажиллагааны хэлтсийн удирдах ажилтан өөрөө сонгон бүрдүүлнэ) ажиллаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах үүрэгтэй.</li> </ul> <p>/Гуравдугаар шатны хяналтыг тухайн байгууллагын гүйцэтгэх удирдлага эсвэл түүний томилсон албан тушаалтнаар удирдуулсан комисс улиралд 1 удаа явуулна. Шалгалтын дүнг тухайн хэсгийн ахлагч, ИТА-уудыг оролцуулан хэлцэж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, хэм хэмжээг зөрчсөн хүмүүст хариуцлага тооцож, илэрсэн зөрчил дутагдлыг хэрхэн арилгах арга хэмжээг тодорхойлж хэрэгжилтэд хяналт тавина/</p>	Дотоод үйл ажиллагааны зардал
<b>Нийт зардал,төг</b>				<b>1,920,000</b>

#### 4.1. Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн ажлууд

Төслийн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн үргэлжлүүлэн явуулах зорилгоор ерөнхий гүйцэтгэгч “Бодь интернэшнл” ХХК-ийн “Аюулгүй ажиллагааны хэлтэс”-ээс бусад хэлтэс нэгж болон туслан гүйцэтгэгч компани руу цаг агаарын 7 хоногийн өдөр тутмын урьдчилсан мэдээг 7 хоногт нэг удаа тогтмол явуулж болзошгүй цаг агаарын аюултай нөхцөл байдлаас урьдчилан сэргийлдэг. Бид салхины хурд 12м/с-ээс дээш үед өргөлт, өндрийн ажил, өндөр хэм /гагнуур/ ажил, 16м/с-ээс дээш болсон үед автосамосвал шороо буулгалтын ажил, 20м/с-ээс дээш салхитай үед бүх ажлыг зогсоож болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажилладаг. Тайлант онд хүчтэй салхитай өдрийн тоо 63 тохиодол байсан. Мөн хүчтэй аадар борооны улмаас 2 удаагийн үер болсон байна.



Зураг 4.1. Мэдээллийг и-мэйлээр хүргүүлж буй байдал

**МОНГОЛ УЛС**  
**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ**  
**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**  
**УРЬДЧИЛАН МЭДЭЭЛЭХ ХЭЛТЭС**

**2022 оны 10 дугаар сарын 14**

Улаанбаатар хот 46  
Жуулчны гудамж - 5

Утас: **326609**, 326603  
Факс: 326614, 263862

**№ 42**

---

**2022 оны 10 дугаар сарын 14-нөөс 10 дугаар сарын 21-нийг хүртэлх цаг агаарын урьдчилсан төлөв:**

**Хур тунадас:** 21-нд Ханбогд орчмоор ялимгүй цас орно. Бусад хугацаанд хур тунадас орохгүй.

**Салхи:** Ихэнх хугацаанд секундэд 6-11 метр, 15,16-нд түр зуур секундэд 16-18 метр хүрч ширүүсэн шороон шуурга шуурна.

**Агаарын температур:** 15, 16-нд хүйтэрч шөнөдөө 0...-5 градус хүйтэн, өдөртөө +6...+11 градус дулаан, бусад хугацаанд дулаарч шөнөдөө +1...+6 градус, өдөртөө +15...+20 градус дулаан байх төлөвтэй.

Monday	Tuesday	Wednesday	Thursday	Friday	Sat	Sun
				9.30	10.1	2
				Цогцэций	Баян-Овоо	Баян-Овоо
				Темп: Шороо +7°C	Темп: Шороо +10°C	Темп: Шороо +11°C
				Одөр +23°C	Одөр +25°C	Одөр +14°C
				Ханбогд	Цогцэций	Цогцэций
				Темп: Шороо +10°C	Темп: Шороо +7°C	Темп: Шороо +5°C
				Одөр +25°C	Одөр +19°C	Одөр +6°C
				Ханбогд	Ханбогд	Ханбогд
				Темп: Шороо +12°C	Темп: Шороо +12°C	Темп: Шороо +10°C
				Одөр +26°C	Одөр +13°C	Одөр +13°C
Monday	Tuesday	Wednesday	Thursday	Friday	Sat	Sun
10.3	10.4	10.5	10.6	10.7	10.8	10.9
Баян-Овоо	Баян-Овоо	Баян-Овоо	Баян-Овоо	Баян-Овоо	Баян-Овоо	Баян-Овоо
Темп: Шороо +1°C	Темп: Шороо -4°C	Темп: Шороо -5°C	Темп: Шороо 0°C	Темп: Шороо 0°C	Темп: Шороо 0°C	Темп: Шороо -8°C
Одөр +4°C	Одөр +9°C	Одөр +11°C	Одөр +16°C	Одөр +15°C	Одөр +3°C	Одөр +12°C
Цогцэций	Цогцэций	Цогцэций	Цогцэций	Цогцэций	Цогцэций	Цогцэций
Темп: Шороо -4°C	Темп: Шороо -6°C	Темп: Шороо -5°C	Темп: Шороо 0°C	Темп: Шороо +3°C	Темп: Шороо -	Темп: Шороо -9°C
Одөр +3°C	Одөр +8°C	Одөр +9°C	Одөр +13°C	Одөр +12°C	Одөр -1°C	Одөр +8°C
Ханбогд	Ханбогд	Ханбогд	Ханбогд	Ханбогд	Ханбогд	Ханбогд
Темп: Шороо +1°C	Темп: Шороо -4°C	Темп: Шороо -2°C	Темп: Шороо +5°C	Темп: Шороо +6°C	Темп: Шороо 0°C	Темп: Шороо -5°C
Одөр +6°C	Одөр +7°C	Одөр +10°C	Одөр +16°C	Одөр +16°C	Одөр +4°C	Одөр +11°C
Monday	Tuesday	Wednesday	Thursday	Friday	Sat	Sun
10.10	10.11	10.12	10.13	10.14	10.15	10.16
Баян-Овоо	Баян-Овоо	Баян-Овоо	Баян-Овоо	Баян-Овоо	Баян-Овоо	Баян-Овоо
Темп: Шороо -6°C	Темп: Шороо -5°C	Темп: Шороо +4°C	Темп: Шороо -1°C	Темп: Шороо +6°C	Темп: Шороо 0°C	Темп: Шороо -4°C
Одөр +17°C	Одөр +19°C	Одөр +16°C	Одөр +16°C	Одөр +20°C	Одөр +10°C	Одөр +10°C
Салхи:	Салхи:	Салхи:	Салхи:	Салхи:	Салхи:	Салхи:
Шороо 6 м/с	Шороо 6 м/с	Шороо 6 м/с	Шороо 6 м/с	Шороо 6 м/с	Шороо 6 м/с	Шороо 4 м/с
Одөр 6 м/с	Одөр 6 м/с	Одөр 6 м/с	Одөр 8 м/с	Одөр 6 м/с	Одөр 6 м/с	Одөр 6 м/с
Хур тунадас:	Хур тунадас:	Хур тунадас:	Хур тунадас:	Хур тунадас:	Хур тунадас:	Хур тунадас:
Шороо	Шороо	Шороо	Шороо	Шороо	Шороо	Шороо
Одөр	Одөр	Одөр	Одөр	Одөр	Одөр	Одөр


Зураг 4.2 Цаг агаарын мэдээний хавсралт

Гал түймрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор төслийн хэмжээнд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус байдлаар сургалт зохион байгуулсан.

2022 онд ХАБЭА-н шинэ ажилтаны сургалтаар 157 хүнд 471 хүн/цаг, галын аюулгүй байдлын тухай сургалтаар 54 хүнд 162 хүн/цаг сургалт орсон.



*Зураг 4.3, 4.4. Шинэ ажилтан болон нийт ажилтны сургалтаар галын аюулгүй байдлын тухай сэдэвчилсэн сургалт*



*Зураг 4.5, 4.6. Нийт ажилчдад галын хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгах, хэрхэн ашиглах талаар сургалтын үеийн зураг*

**БҮЛЭГ 5. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

*Хүснэгт 4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт*

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Зардал, төг
Ахуйн	Ахуйн гаралтай хог хаягдлыг ангилан ялгаж дахин ашиглах, зайлуулах арга хэмжээнүүдийг тодорхойлох	Төслийн бүх төрлийн байгууламжууд	<p>Өмнөговь аймгийн Цогтцэций сумын “Тэгш дүүрэн тохижилт” ОНӨААТҮГ-тай 4 туслан гүйцэтгэгч компани хог хаягдлын үйл ажиллагаа эрхлэх гэрээ гэрээ байгуулж, гэрээний дагуу 1,160,000 төгрөгийн төлбөрийг төлж, харъяа сумдын нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлж ажилласан. /Хог хаягдлын гэрээ, төлбөр төлсөн баримтуудыг хавсаргав./</p> <p>Хог хаягдлаас үүдэлтэй хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах зорилгоор “Хог хаягдлын тухай хууль”, “Байгаль хамгаалах тухай хууль” болон байгууллагын дотоод “Хог хаягдлын журам”-ыг туслан гүйцэтгэгч байгууллагын нийт 124 ажилчдад танилцуулж, сургалт зохион байгуулж, зааварчилгаа өгч ажилласан.</p> <p>Сар бүрийн 25-ны өдөр бүх нийтийн хог хаягдлын цэвэрлэгээг зохион байгуулж байна. Мөн сум орон нутгаас зохион байгуулсан бүх нийтийн хог хаягдлын цэвэрлэгээнд хүн хүч, техник гарган хамтран ажилласан.</p>	8.432.000
Үйлдвэрийн	Үйлдвэрлэлийн гаралтай хаягдлыг ил задгай зориулалтын битүү ангилан ялгаж, хадгалах дахин ашиглах болон үйлдвэрлэгчид нийлүүлэх арга хэмжээнүүдийг	Төслийн бүх төрлийн байгууламжууд	<p>ТНАЛТ төслийн барилга байгууламжийн ажлын явцад гарсан нийт 1212 тн барилгын хог хаягдлыг Цогтцэций сумын нэгдсэн хогийн цэгт тээвэрлэн төвлөрүүлсэн. Барилгын хог хаягдлын төлбөр 7,272,000 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.</p> <p>Хаягдал дугуй, бетон, мод зэргийг тохижилтын ажил /саравч, сандал, ширээ, явган хүний зам, хогийн сав/ болон орон нутгийн иргэдийн хүсэлтээр дахин ашиглуулахаар өгсөн.</p>	

	тодорхойлох			
<b>Нийт зардал, төг</b>				<b>8.432.000</b>




Өмнөговь аймгийн Цогтцэций сумын “Тэгш дүүрэн тохижилт” ОНӨААТҮГ-тай 4 туслан гүйцэтгэгч компани хог хаягдлын үйл ажиллагаа эрхлэх гэрээ гэрээ байгуулж, гэрээний дагуу 1,160,000 төгрөгийн төлбөрийг төлж, харъяа сумдын нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлж ажилласан. /Хог хаягдлын гэрээ, төлбөр төлсөн баримтуудыг хавсаргав./

Хүснэгт 5.1. Хог хаягдлын төрөл болон тоо хэмжээний мэдээлэл

№	Байршил /Аймаг, сум, /	Хог хаягдлын төрөл											
		Энгийн хог хаягдал /тн/			Аюултай хог хаягдал /тн/								
		Дахин боловсруулах боломжит	Үнс	Бусад	Гидрийн шингэн	Будаг, лак арилгагч	Тос, тосолгоо	Битум	Батерей, аккумулятор	Тосоор бохирдсон даавуу	Тосны шүүр	Бусад	
1	Өмнөговь, Цогтцэций	5.2	2	1561	0.4	1.18	1.8	3.5	0.1	0.05	0.33	0.3	

График 5.1. Хог хаягдлын төрөл болон тоо хэмжээний мэдээлэл



Хог хаягдлаас үүдэлтэй хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах зорилгоор “Хог хаягдлын тухай хууль”, “Байгаль хамгаалах тухай хууль” болон байгууллагын дотоод “Хог хаягдлын журам”-ыг туслан гүйцэтгэгч байгууллагын нийт 124 ажилчдад танилцуулж, сургалт зохион байгуулж, зааварчилгаа өгч ажилласан.

Сар бүрийн 25-ны өдөр бүх нийтийн хог хаягдлын цэвэрлэгээг зохион байгуулж байна. Мөн сум орон нутгаас зохион байгуулсан бүх нийтийн хог хаягдлын цэвэрлэгээнд хүн хүч, техник гарган хамтран ажилласан.



*Зураг 5.1, 5.2. Байгаль орчны сургалтын зураг*



*Зураг 5.3, 5.4 Сар бүрийн 25-ны өдөр нийтийн цэвэрлэгээг зохион байгуулав.*



Зураг 5.5. Цогтцэций сумаас зохион байгуулсан бүх нийтийн хог хаягдлын цэвэрлэгээнд оролцов



Зураг 5.6. Хуванцар хог хаягдал ангилан ялгах сав

**БҮЛЭГ 6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ**

*Хүснэгт 6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт*

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Ажлын гүйцэтгэл	Зардал, төг
<b>1. ГАЗРЫН ДООРХ УС</b>				
Химийн ерөнхий чанар рН, нийт ууссан хатуу бодисын хэмжээ, нийт хатуулаг, цахилгаан дамжуулах чанар, усны түвшин	Төсөлд ашиглагдах хугцуудаас дээж авах	Жилд 1 удаа дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө.	Өмнөговь аймгийн мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн сорилтын лабораторид 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдөр 1л дээж өгч, MNS 1097:1970 /Кальци, Магни, Хатуулаг, /, MNS ISO 10523:2001 /рН/, MNS 4424:2005 /Хлорид/, MNS 4423:1997 /Хуурай үлдэгдэл/, MNS ISO 7888:1999 /цахилгаан дамжуулах чанар/, MNS 6831:2020 /Гидрокарбонатын агуулга/ зэргийг шинжлүүлэхэд зөвшөөрөгдөх хэмжээнд байна. /Шинжилгээний хариуг хавсаргав/	44,200
<b>2. ХӨРСӨН БҮРХЭВЧ</b>				
Хөрсний өнгөн болон дээд үе давхаргын элсжилт, чулуужилт, тоосжилт зэрэг морфологи тогтцын	Төслийн талбайн ойролцоо нэг байршилд нөлөөлөлд өртөөгүй талбайд	Жилд 1 удаа дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд	Өмнөговь аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв дэх Байгаль орчны шинжилгээний лабораторид Агрохимийн үзүүлэлтээр /рН, чийг, Сульфат SO <sub>4</sub> , Нитрат NO <sub>3</sub> , Амони NH <sub>4</sub> , ялзмаг, Фосфор P <sub>2</sub> O <sub>5</sub> / ТНАЛТ төслийн барилгын ажлын талбайн орчим хяналтын 2 цэгт дээж авч шинжлүүлсэн. /Шинжилгээний хариуг хавсаргав/	114,000
<b>Нийт зардал, төг</b>				<b>158,200</b>



*Зураг 6.1. Хөрсний дээж авч буй байдал*

**БҮЛЭГ 7. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгөөр үйл ажиллагаа явуулах, төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах үүргийг төсөл хэрэгжүүлэгчийн удирдлага хүлээнэ. Зохион байгуулалтын арга хэмжээний зардлыг дор тусгав.

*Хүснэгт 7. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт ба зардал*

<b>Хэрэгжүүлэх арга хэмжээ</b>	<b>Ажлын гүйцэтгэл</b>	<b>Зардал, төг</b>
Ажиллагсдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	Өмнөговь аймгийн нэгдсэн эмнэлэгт нийт 32 ажилтан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан.	1,600,000
Тухайн жилийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрх бүхий байгууллагад тайлагнах	Гүйцэтгэж буй ажил	-
Жил бүрийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах	Хугацаа болоогүй	-
<b>Нийт зардал, төг</b>		<b>1,600,000</b>

**БҮЛЭГ 8. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ**

БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Зохион байгуулах газар	Зардал, төг
Өмнөговь аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар	БОМТ-ний тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлнэ.	Гүйцэтгэж буй ажил	-
Багийн иргэдийн нийтийн хурал	БОМТ-ний тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж хүргүүлэх	Цогтцэций сумын Сийрст багийн хурал, ААН-ийн уулзалтанд оролцож иргэдийн санал, хүсэлтийг сонссон.	-
<b>Нийт дүн</b>			



Зураг 8.1. Цогтцэций сумын Сийрст багийн нийтийн хуралд оролцож иргэдийн санал хүсэлтийг сонсов



Зураг 8.2. Цогтцэций сумын ААН-ийн уулзалтанд оролцож иргэдийн санал хүсэлтийг сонсов



Зураг 8.3. Малчдын санал хүсэлтийг сонсов

## **ХАВСРАЛТ МАТЕРИАЛ**

1. Ус ашиглах, ашиглуулах гэрээ
2. Усны шинжилгээний дүгнэлт
3. Хөрсний шинжилгээний дүн
4. Хог хаягдлын гэрээ, төлбөр төлсөн баримт



БАТЛАВ  
“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН  
САЛБАРЫН ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭХУЯГ

БАТЛАВ  
“ГОВЬ ИНФРАСТРАКЧЕР ПАРТНЕРС”  
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ЖОНОН

### УС АШИГЛАХ, АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ

2022 оны 5 сарын 18 өдөр

№ЭТТ-СА-2022/03 Өмнөговь, Цогтцэций сум


Иргэний хуулийн холбогдох зүйл, заалтуудыг үндэслэн нэг талаас “Эрдэнэс Тавантолгой” ХК /цаашид “Ус ашиглуулагч” гэх/, түүнийг төлөөлж Байгаль орчин, усны бодлогын хэлтсийн дарга С.Ганбат, нөгөө талаас “Говь Инфраструкчер Партнерс” ХХК /цаашид “Ус ашиглагч” гэх/, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Б.Жонон нар /цаашид хамтад нь “Талууд” гэх/ дараах зүйлийг харилцан тохиролцож энэхүү Ус ашиглах, ашиглуулах гэрээ /цаашид “Гэрээ” гэх/-г байгуулав.

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү Гэрээгээр “Эрдэнэс Тавантолгой” ХК нь компанийн дунд хугацааны А6-20 Бизнес төлөвлөгөөнд тусгагдсан “Тавантолгойн Нүүрс Ачих Логистикийн Төв”-ийн төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор уг төслийн ерөнхий гүйцэтгэгч “Бодь Интернэшнл” ХХК-ийн ерөнхий туслан гүйцэтгэгч “Говь Инфраструкчер Партнерс” ХХК-д өөрийн уурхайд байрлах худгуудаас усыг компанийн Салбарын удирдлагын баталсан хуваарийн дагуу ашиглуулах, мөн “Говь Инфраструкчер Партнерс” ХХК нь Гэрээнд заасан төлбөрийг төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Ус ашиглуулагч нь ашиг олох зорилгогүй, тухайн усыг олгохтой холбогдон гарах үйл ажиллагааны зардлыг Ус ашиглагчаас авч байгаа болно.
- 1.3. Ус ашиглуулагчийн гүний худгийн ус нь Өмнөговь аймгийн Стандартчилал, хэмжил зүйн хэлтсийн шинжилгээний бичиг, Мэргэжлийн хяналтын байцаагчийн дүгнэлттэй бөгөөд чанарын шаардлага хангасан болно.

### ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1. Гэрээний хугацааг Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр дор дурдсанаар тогтоосон бөгөөд хуанлийн тооллыг удирдлага болгоно.
- 2.2. Гэрээ нь байгуулагдсан өдрөөс 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байна.
- 2.3. Гэрээ нь Талууд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох ба Талууд Гэрээг хамтран дүгнэж, энэ тухай акт үйлдсэнээр дуусгавар болно.



## ГУРАВ. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- 3.1. Усны төлбөрийг тооцохдоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Засгийн газрын тогтоолуудын дагуу үнийг тогтоох ба үүн дээр ус олгохтой холбоотой үйл ажиллагааны нэмэлт зардлуудыг тооцно.
- 3.2. Гэрээний дагуу ашиглуулсан усны төлбөрийг Ус ашиглуулагчийн Гүйцэтгэх захирлын баталсан унд ахуйн ба уул уурхай үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах усны үнэлгээгээр тооцох ба энэ үнэд НӨАТ багтсан болно. /Гэрээний Хавсралт №1 Усны үнэлгээ/
- 3.3. Ус ашиглуулагч нь Ус ашиглагчийн тухайн сард ашигласан усны төлбөрийг өөрийн үйл ажиллагаа явуулж байгаа объектын усны тоолуурыг Ус ашиглагчийн бүртгэлтэй тулгаж баталгаажуулсны үндсэн дээр төлбөрийн нэхэмжлэхийг сар бүрийн 05-ны өдрийн дотор хүргүүлнэ.
- 3.4. Ус ашиглагч нь тухайн сарын ус ашигласан төлбөрийг дараа сарын 10-ны өдрийн дотор Ус ашиглуулагчийн Төрийн банк дахь 3465 0227 3740 тоот дансанд шилжүүлнэ.

## ДӨРӨВ. УС АШИГЛУУЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1. Ус ашиглуулагч нь Ус ашиглагчаас Гэрээгээр тохиролцсоны дагуу ус ашигласны төлбөрийг хугацаанд нь төлөхийг шаардах эрхтэй.
- 4.2. Ус ашиглуулагч нь Ус ашиглагчаас Салбарт мөрдөгддөг Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчин, эрүүл ахуйн дүрэм, журам, горим, зааврыг дагаж мөрдөх, Салбарын эрх бүхий удирдах ажилтнууд болон харуул хамгаалалтын ажилтнуудын тавьсан шаардлагыг бүрэн биелүүлж ажиллахыг шаардах эрхтэй.
- 4.3. Ус ашиглуулагч нь гүний худаг ашиглах, ус гүнээс гаргахтай холбоотой өөрийн дотоод үйл ажиллагааны зардалтай уялдуулан Ус ашиглагчид мэдэгдсэний үндсэн дээр гэрээний үнийг тухай бүр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулан өөрчилж болно.

## ТАВ. УС АШИГЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1. Ус ашиглагч нь Ус ашиглуулагчийн тогтоосон усны үнийг ашиг олох зорилгогүйгээр тогтоосон гэдэгт итгэл үнэмшилтэй байхын тулд Ус ашиглуулагчаас усны үнэ тогтоосон задаргааг шаардах эрхтэй.
- 5.2. Гэрээнд заасны дагуу Ус ашиглагч нь Ус ашиглуулагчийн гүний худгийн усыг Ус ашиглуулагчийн үйл ажиллагаанд саад болохгүйгээр авах эрхтэй.
- 5.3. Ус ашиглагч нь үйл ажиллагаандаа ус ашиглахдаа худагт байрлах усны бүртгэлийн дэвтэрт авсан усны хэмжээг тухай бүр тэмдэглүүлж, сар бүрийн 25-ны өдөр усны хэрэглээний актаар хэрэглэсэн усны хэмжээг баталгаажуулна.
- 5.4. Ус ашиглагч нь үйл ажиллагаандаа ашиглаж буй худагт эвдрэл, гэмтэл гаргасан тохиолдолд өөрийн зардлаар засвар хийж Гэрээ дуусгавар болоход

ашигласан худгийг хийгдсэн засан сайжруулалтын хамтаар Ус ашиглуулагчид хүлээлгэн өгнө.

- 5.5. Ус ашиглагч нь үйл ажиллагаандаа ашиглаж буй худгийн ойр орчмын цэвэрлэгээ, үйлчилгээг хийхэд дэмжлэг үзүүлнэ.

### **ЗУРГАА. ХАРИУЦЛАГА**

- 6.1. Ус ашиглагчийн буруутай үйл ажиллагааны улмаас Ус ашиглуулагчид учирсан хохирлыг Ус ашиглагч нь өөрийн зардлаар бүрэн хариуцан барагдуулна.
- 6.2. Торгууль төлсөн, хохирол барагдуулсан нь Талуудыг Гэрээгээр хүлээсэн үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 6.3. Ус ашиглагч нь ус ашигласны төлбөрийг Гэрээний 3.4-т заасан хугацаанаас хэтрүүлсэн бол тухайн өдрөөс эхлэн хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувийн алдангийг Ус ашиглуулагчид төлнө.

### **ДОЛОО. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ**

- 7.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талууд аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу биелүүлэх боломжгүй болсон бол нөгөө талдаа ажлын 5 өдрийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэ нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдож болно.
- 7.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн гуч хоногоос дээш хугацаагаар үргэлжилбэл Талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэж болно.

### **НАЙМ. ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ**

- 8.1. Талууд харилцан тохиролцсоноор Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд оруулах нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж талуудын гарын үсгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно. Ийнхүү оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь энэ гэрээний нэгэн адил хүчин төгөлдөрт тооцогдох бөгөөд гэрээний салшгүй хэсэг байна.
- 8.2. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд шийдвэрлэж эс чадвал Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

### **ЕС. ТАЛУУД ХАРИЛЦАХ**

- 9.1. Гэрээтэй холбоотойгоор Талууд хоорондоо харилцахдаа дараах мэдээллийг үндэслэнэ.
- 9.1.1. Ус ашиглуулагч /“Эрдэнэс Тавантолгой” ХК/:  
Нэр: А.Батзаяа  
Албан тушаал: Байгаль орчны мэргэжилтэн  
Утас: 88088576  
И-мэйл: [batzaya.a@erdenestt.mn](mailto:batzaya.a@erdenestt.mn)

Нэр: Б.Оргил  
Албан тушаал: Байгаль орчны мэргэжилтэн  
Утас: 99064609  
И-мэйл: [orgil.b@erdenestt.mn](mailto:orgil.b@erdenestt.mn)

9.1.2. Ус ашиглагч /“Говь Инфраструкчер Партнерс” ХХК/  
Нэр: М.Мэндсайхан  
Албан тушаал: Барилга угсралтын менежер  
Утас: 88108044  
И-мэйл: [mendsaikhan.m@gip.mn](mailto:mendsaikhan.m@gip.mn)

### АРАВ. БУСАД

10.1. Гэрээг Монгол хэл дээр 3 хувь үйлдэх бөгөөд Ус ашиглуулагч 2 хувь, Ус ашиглагч 1 хувийг тус тус хадгална. Гэрээний хувь тус бүр хууль, эрх зүйн хувьд адил хүчинтэй байна.

10.2. Энэ Гэрээ нь хавсралтын хамт хүчинтэй бөгөөд доорх хавсралтууд гэрээний салшгүй хэсэг байна.

- 10.2.1. Хавсралт №1 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны А/173 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт “Усны үнэлгээ”  
10.2.2. Хавсралт №2 “Бодь Интернэшнл” ХХК-ийн 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн В1-ТСТS-LTR-0138 тоот “Дэмжлэг хүсэх тухай” албан бичиг

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

УС АШИГЛУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:  
“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН  
БАЙГАЛЬ ОРЧИН, УСНЫ  
БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГА



С.ГАНБАТ

Хаяг: Өмнөговь аймаг, Цогтцэций сум,  
Цагаан-Овоо баг  
Утас: 75055555

УС АШИГЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:  
“ГОВЬ ИНФРАСТРАКЧЕР ПАРТНЕРС”  
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ЖОНОН

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,  
15-р хороо, Шинэ мянганы барилга 5  
давхар  
Утас: 70009797



ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ  
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 9/173

Улаанбаатар хот

Зарим ажил үйлчилгээний үнэлгээг  
шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн дүрмийн 9.5.3, Хөдөлмөрийн дотоод журмын 2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн туслан гүйцэтгэгч компаниудад дамжуулан үйлчилгээ үзүүлж буй цахилгаан эрчим хүчний 1 кВт-ын өртгийг нэгдүгээр хавсралтаар, усны үнэлгээг хоёрдугаар хавсралтаар, саарал ус тээвэрлэх ажлын үнэлгээг гуравдугаар хавсралтаар, цэвэр ус тээвэрлэх үнэлгээг дөрөвдүгээр хавсралтаар, "Цанхи" хотхоны гэр болон контейрийн түрээсийн үнэлгээг тавдугаар хавсралтаар, "Цанхи" хотхонд байрлах хүн хөногийн үнэлгээг зургаадугаар хавсралтаар, Нүүрс тээврийн нэг тэвш хучих үнэлгээг долоодугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Дээрх ажил үйлчилгээний үнэлгээг 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхийг Салбарын захирал /Н.Эрдэнэхуяг/-д даалгасугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2018 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн "Зарим үйлчилгээний үнэлгээг тогтоох тухай" А/243 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, өрөдлолын удирдлагын газар /Х.Пурлат/-т даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ГАНХУЯГ

1100001396

"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК  
ӨМНӨГОВЬ АЙМАГ ЦОГЦЭЦЭН  
СУМ ДАХЬ САЛБАР

